

**ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ПҮРЭВЖАВЫН ТҮВШИНЖАРГАЛЫН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт /	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 2.13 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст орж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	Газрын даргын 2025 оны А/07, А/05, А/39, А/52, А/67 дугаар тушаалаар байгуулагдсан 5 удаагийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн хуралд гишүүнээр оролцсон байна. Үүнд: 1. Газрын даргын 2025 оны А/05 дугаар тушаал "Өргөө амаржих" газрын цайны газрын түрээсийн сонгон шалгаруулалт 2. Газрын даргын 2025 оны А/07 дугаар тушаал Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд цайны газрын түрээсийн сонгон шалгаруулалт 3. Газрын даргын 2025 оны А/39 дүгээр тушаал Сүхбаатар дүүргийн Хүрээ амаржих газрын гадна 30 автомашины зогсоолын түрээсийн сонгон шалгаруулалт 4. Газрын даргын 2025 оны А/52 дугаар тушаал Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн төв буфетын түрээсийн сонгон шалгаруулалт 5. Газрын даргын 2025 оны А/67 дугаар тушаал Налайх дүүргийн Боловсрол сургуулийн цайны газрын түрээсийн сонгон шалгаруулалт Ажлын хэсгийн сонгон шалгаруулалтад тухай бүр оролцож, нийслэлийн түрээсийн сонгон шалгаруулалтын журмын дагуу түрээслэгчийг сонгон шалгаруулж ажлын хэсгийн гишүүний үүргийг бүрэн гүйцэтгэсэн.	01.01 06.30	100%

2	<p>Арга хэмжээ 2.19 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн ажилд захиалагчийн хяналт тавих, захиалагчийн хяналт тавьсан төсөл, арга хэмжээний 5%-ийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх</p>	<p>Санхүүжилтийн дүн, сая төгрөг, арга хэмжээний тоо</p>	-	-	<p>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд 2024 оны жилийн эцсээр нийт 3 арга хэмжээнд хөрөнгө хүлээн авах ажлын хэсэгт орж ажилласан байна.</p> <p>1.Нийслэлийн хөрөнгө оруулалтын Газрын даргын 2024.12.09 өдрийн А/175 тушаалаар Сонгинохайрхан дүүргийн хороодод иж бүрэн компьютер хүлээлцэх ажил</p> <p>2.Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024.12.16-ны өдрийн А/192 дугаар тушаалаар Төв цэнгэлдэх хүрээлэнд авто зогсоол шинээр байгуулах ажлыг байнгын ашиглалтад хүлээж авах ажил</p> <p>3.Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2024.12.17-ны өдрийн А/290 тушаалаар Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 220/110/35 кВ-ын “Багануур” дэд станцын 110 кВ-ын хувиарилах байгууламжийн өргөтгөл, 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35 кВ-ын станц, 50 МВт-ын хүчин чадалтай 200 МВт.ц-ийн багтаамж бүхий эрчим хүч хуримтлуурын станцын барилга угсралт хүлээн авах ажил</p> <p>Тус хөрөнгө хүлээн авах ажлууд нь 2024 оны жилийн эцсийн тайланд тусгагдаагүй учир нэмэлтээр оруулав.</p>	<p>2024.12.09 2025.01.10</p>	100%
3	<p>Арга хэмжээ 2.29 Холбогдох хууль тогтоомж, журмын төсөлд санал өгөх</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	3	50%	<p>Хувийн тэтгэвэрийн тухай хуулийн төсөл, Дулаан хангамжийн хуулийн төсөл, Худалдан авах ажиллагааны тухай хууль, Нийтийн Өмчийн тухай хуулийн төсөл, Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй тус тус танилцсан. Мөн өмчийн бүртгэлийн программ хангамжийн сайжруулалтын системийн баримт бичиг нэгжийн албан хаагчдын хамт 4 санал өгсөн.</p>	<p>01.01 06.30</p>	100%

4	<p>Арга хэмжээ 2.31 Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллах</p>	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100%	<p>Тайлант хугацаанд газрын даргын 3 удаагийн тушаалаар төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажилласан.Үүнд:</p> <p>1. Газрын 2024 оны А/798 дугаар тушаалаар ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдон нийслэлийн өмчит төвийн 6 дүүрэгт нийт 112 барилга байгууламжийг түүвэрлэн сонгож 2025 оны 01 дүгээр сарын 13-24-ний өдрүүдэд ажлын хэсгийн гишүүдийн хамт хяналт шалгалтаар явсан. Ажлын хэсгийн тайланг нэгтгэн сул байр талбай, илүүдэлтэй байр талбай, түрээсийн гэрээний талаар танилцуулга мэдээллийг нэгтгэн байгууллагын удирдлага, нэгжийн даргад 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр танилцуулсан.</p> <p>2. Газрын 2024 оны А/40 дугаар тушаалаар 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 04 дугаар сарын 22-ны өдрүүдэд ажлын хэсгийн гишүүдийн хамт нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээтэй эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг газар дээр нь очиж танилцан ажиллаа. Батлагдсан удирдамжийн дагуу нийслэлийн 6 дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн 222 байгууллагын барилга байгууламжийн илүүдэлтэй байр талбай, түрээсийн гэрээ, бүртгэлийн болон бэлэн мөнгөний автомат машин байршуулсан эсэхийг газар дээр нь үзэн холбогдох зөвлөмж зөвлөгөөг өгч, тэмдэглэл хөтлөн, бодит байдлыг фото зургаар баримтжуулан, судалгаа хийн, зөрчлийг илрүүлэн ажиллаа. Хяналт шалгалтаар 6 дүүргийн 37 Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, 168 ӨЭМТ-ийн байр, талбайн ашиглалтыг газар дээр нь шалгасан.</p> <p>Үүнд: ӨЭМТ-ийн барилга байгууламжаас дүүргийн ЗДТГ-ын баланст 133, ӨЭМТ-ийн</p>	01.01 06.30	100%
---	---	---------------------------------	---	------	--	----------------	------

				<p>баланст 8 барилга бүртгэлтэй, түрээсийн гэрээтэй 25 ӨЭМТ байна. Дүүргийн нийт 15 Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгээс барилгын илүүдэлтэй байр, талбайн 3 талт түрээсийн гэрээтэй 13, шууд түрээсийн гэрээ байгуулсан 13 эмнэлэг байна.</p> <p>1. Газрын 2024 оны А/62 дугаар тушаалаар 2025 оны 05 дүгээр сарын 04-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрүүдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Нийслэлийн 6 дүүргийн 137 ерөнхий боловсролын дунд сургуулийн цайны газрын байр талбайг шалгахад Үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэгч 82 сургууль үлдсэн 55 сургуульд 60 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>“Үдийн хоол” хөтөлбөрийг 82 сургууль өөрөө хэрэгжүүлэн, хөтөлбөрт хамрагдаж байгаа бага ангийн сурагчдын тооноос хамааран цайны газарт хоол зүйч, нярав, бэлтгэгч, тогооч гэсэн 6-10 ажилтан орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Үүнд :</p> <p><i>Хан-Уул дүүрэгт-18,</i> <i>Сонгинохайрхан дүүрэгт -11,</i> <i>Баянзүрх дүүрэгт -15,</i> <i>Баянгол дүүрэгт -18,</i> <i>Чингэлтэй дүүрэгт -10,</i> <i>Сүхбаатар дүүрэгт -10</i></p> <p>“Үдийн хоол” хөтөлбөр, сургуулийн цайны газрын үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа 60 аж ахуйн нэгжээс нийслэлийн Өмчийн харилцааны газартай түрээсийн гэрээтэй- 55, сургуультай түрээсийн гэрээтэй- 10 аж ахуйн нэгж байна. Үүнд:</p> <p><i>Хан-Уул дүүрэгт-4,</i> <i>Сонгинохайрхан дүүрэгт -18,</i> <i>Баянзүрх дүүрэгт -20,</i> <i>Баянгол дүүрэгт -4,</i></p>		
--	--	--	--	--	--	--

					<p>Чингэлтэй дүүрэгт-7, Сүхбаатар дүүрэгт-7 Цайны газар, “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж сургуулийн дунд, ахлах ангийн сурагчид, багш, ажилчдад хөнгөлттэй үнийн хоолоор үйлчилдэг, ус ундаа, жижиглэн хүнсний бүтээгдэхүүний буфет ажиллуулж байна.</p> <p>Дээрх хяналт шалгалтын ажлын тайланг нэгтгэн, нэгжийн албан хаагчдын хамт 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэсэн.</p>		
ХОЁР. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
5	Арга хэмжээ 3.2 Хяналт шалгалтын байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах	Ирүүлсэн зөвлөмжийн тоо, хэрэгжилтийн хувь	-	50%	<p>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын үүрэг даалгавар, Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 1 ажлын хэсэг, Газрын даргын тушаалаар байгуулагдсан 1 ажлын хэсгийн хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Үүнд:</p> <p>1. Таван толгой түлш ХХК нийслэлд шилжин ирж байгаатай холбоотой түлш борлуулах агуулах болон газрын мэдээлэл, нийслэлийн Өмчийн харилцааны газрын балансад бүртгэлтэй тус газруудад 2025-2028 онуудад хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудын судалгаа, таван толгой түлш борлуулах агуулахыг бодит байдал зэрэг танилцуулга бэлтгэнн, 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр нэгжийн удирдлагад тайлагнасан.</p> <p>2. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/307 дугаар захирамжаар байгуулагдсан "Улаанбаатар смарт карт" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ти мони" ХК-ийн нийслэлд шилжүүлэх 55 хувийн хувьцаанд ногдох биет болон биет бус хөрөнгийг хүлээн ажилд нэгжийн удирдлагын үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын</p>	01.01 06.30	100%

				<p>газрын дарга Л.Эрдэнэбадрах даргаар ахлуулсан биет хөрөнгө тоолох, хүлээлцэх дэд ажлын хэсэг 2025.04.17-04.23-ны өдрүүдэд Сити товер барилгын 4 давхарт байрлах “Улаанбаатар смарт карт” ХХК-ний төв байр биет хөрөнгө буюу 33.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй тавилга эд хогшил, 93.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй цахилгаан тоног төхөөрөмж, 67.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 5 тээврийн хэрэгсэл, 5.0 сая төгрөгийн 2 контейнер, бүртгэлгүй 26 сая төгрөгийн Ти мони ХК-аам ирүүлсэн 26.2 сая төгрөгийн хөрөнгийг тоолж, тухай бүр лац нааж баталгаажуулан хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. Тооллогын актад ажлын хэсгийн гишүүдээр гарын үзэг зуруулан баталагаажуулсан. Биет бус хөрөнгийг хүлээлцэх ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 23-ний өдөр хуралдаж сорс код, серверийн тоног төхөөрөмжийг тоолж, хүлээлцэх төлөвлөгөөний хуваарьт өөрчлөлт оруулсан. Биет бус хөрөнгийг хүлээн авахад БНСУ-ын хөгжүүлэгч байгууллагаас инженерүүдийг байлцуулан хүлээн авах санал гарсны дагуу системийн 1 инженер ирж программ хангамжийг үе шаттай хүлээлцэх ажлыг эхлүүлсэн. Мөн серверийн өрөөнд байрлах хөрөнгийг хүлээлцэж ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Тус ажлын 2 удаагийн хурлын тэмдэглэл дэд ажлын хэсгүүдийн хурлыг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>3. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан “Улаанбаатар радио” ХХК-ын эзэмшиж байгаа барилга, газрыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Баруунсэлбэ үйлчилгээний төвийн Ж блокийн барилгын гадна болон дотор талын өрөө, тасалгаа, цахилгааны монтажны хэсгийг газар дээр нь очин хөрөнгийг тоолж, нүд үзэн хүлээлцсэн. Хөрөнгө хүлээлцэсэн ажлын хэсгийн акт илтгэх хуудас</p>		
--	--	--	--	--	--	--

					холбогдох баримтыг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр газрын даргад танилцуулав.		
6	Арга хэмжээ 3.6 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих	Модны тоо, Өртөг, сая төг	25	50%	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны хаврын "Бүх нийтийн мод тарих", тариалсан мод, бут, сөөгийг арчлан хамгаалах арга хэмжээний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын хамт олноороо Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд 160 хайлаас суулгаж, усалж, арчилснаас гадна өнгөрсөн онуудад суулгаж, ургуулсан мод, бут, сөөгөө усалгааг хийсэн.	01.01 06.30	100%
7	Арга хэмжээ 6.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	50%	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэлийн болон байгууллагын удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу мэдээ, мэдээллийг тогтмол цаг тухай бүр гаргаж ажилласан.	01.01 06.30	100%
8	Арга хэмжээ 6.3 Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, хяналт тавих	Үүрэг даалгаврын тоо, гүйцэтгэлийн хувь	65 100%	- 100%	Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 3 үүрэг даалгаварын биелэлтийг ханган ажилласан. Үүнд: 1. Нийслэлийн өмчийн балансад бүртгэлтэй Соёлын Төв өргөөний Г блокд байрлах нийслэлийн харьяа 6 байгууллага, 24 иргэн, аж ахуй нэгжийн 150 гаруй өрөө тасалгааг тоолсон. Нийт 30 иргэн аж ахуй нэгжид байр талбай чөлөөлөх тухай мэдэгдэх хуудсыг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 01 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд сул байр талбай ашиглалтын мэдээллийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр танилцуулсан. 2. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны Барилгачидын гудамжид барилгын хашаан дотор байрлах сурталчилгааны самбар 2012, 2013 онуудаас хойш байрлаж байна. Тус объектын талаар хорооны ажилтан, барилга	01.01 06.30	100%

					барихаар төлөвлөсөн компаниас мэдээллийг авч удирдлагад танилцуулсан. 3. “Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төв”-ийн харьяа “Богд уул” сувиллын хөрөнгийг тоолох ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн баг бүрэлдэхүүнтэй хамтран газар дээр нь очиж, хөрөнгийг тоолж, хүлээлцэх ажилд хяналт тавьсан.		
9	Арга хэмжээ 7.3 Албан хаагчийн албан үүргээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдах	Арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь	5 сургалт 100%	3 сургалт 100%	Дараах сургалтад мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хамрагдсан байна. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хамрагдсан. 2.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэнүүдтэй уулзалт, сургалт зохион байгуулахад нэгжийн хамт олны хамт оролцсон. 3. Нийслэлийн онцгой байдлын газраас зохион байгуулсан гамшгийн үеийн сургалт мэдээлэлд танхимаар болон биечлэн оролцсон. 4.Нийслэлийн өмчийн нэгдсэн программын сургалтад 3 удаа хамрагдсан байна.	01.01 06.30	100%
ГУРАВ. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
10	Арга хэмжээ 9.1 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдлыг	Албан бичиг, өргөдөл гомдлын тоо, хэрэгжилтийн хувь	Албан бичиг 75, 100% Өргөдөл 1, 100%	100%	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж нийт 3 албан бичиг ирснийг цаг тухай бүр шийдвэрлэж, 5 албан бичгийг иргэн, аж ахуй нэгжид илгээсэн байна. Мөн өргөдөл гомдлын системээр 1 гомдол ирснийг зохих журмын дагуу зөрчилгүй шийдвэрлэсэн байна. Иргэний гомдлын шинжтэй өргөлдийг 2025 оны 3/327 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн байна.	01.01 06.30	100%

хугацаанд нь шийдвэрлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх							
---	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ны биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт /	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Цаг үеийн асуудлаар шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагааний хэрэгжилт хувь	10 арга хэмжээ, 100%	100%	Байр талбай хүлээлцэх, хэмжилт хийсэн тухай тэмдэглэл хийсэн ажлууд: 1.БЗД-ийн Шархадны эцсийн буудлын зогсоол дээр байрлах цайны газар, ломбардын байр талбай дээр 2025.02.12-ны өдөр хэмжилт хийж, хөрөнгийг Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын аж ахуйн ажилтанд хүлээлцүүлсэн. 2.БЗД-ын 14 дүгээр сургуулийн цайны газар, буфетын талбайн хэмжээг 2025.02.13-ны өдөр газар дээр нь очиж хэмжилт хийсэн. 3.Сонгинохайрхан дүүргийн 32 хороонд байрлах "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-ийн эзэмшил газрын ашиглалтад хяналт хийсэн. 4.Баянзүрх дүүргийн 127 дугаар сургуулийн цайны газрын гэрээ сунгах хүсэлтийн дагуу 2025.02.20-ны өдөр байр талбайн хэмжилт хийсэн. 5.Баянгол дүүргийн Усан спорт сургалтын төвийн дотор үйл ажиллагаа явуулж байсан талбай дээр 2025.02.24-ний өдөр очиж хяналт тавьсан. 2025 онд түрээсийн гэрээ сунгахгүй болсон нөхцөл байдал болон байр талбайг хэмжээг нүдээр үзэж,	01.01 06.30	100%

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт /	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					сургалтын төвийн удирдлагаас мэдээлэл авсан.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Үйл ажиллагаатай холбоотой шинэчлэгдсэн хууль, дүрэм, журам болон бусад холбогдолтой эрх зүйн актуудыг судалж мэдлэг чадвараа дээшлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	50%	Хувийн тэтгэвэрийн тухай хуулийн төсөл, Дулаан хангамжийн хуулийн төсөл, Худалдан авах ажиллагааны тухай хууль, Нийтийн Өмчийн тухай хуулийн төсөл, Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, СӨХ-ийн тухай хууль зэрэгтэй тус тус танилцсан. Тухайн жил нийслэлээс баталсан бодлогын баримт бичгүүд стратеги төлөвлөгөөтэй танилцан холбогдох сургалтад хамрагдсан. Мөн Сангийн яамнаас гаргасан Улсын салбарын дотоод аудит, Монголын үндэсний дотоод аудитын холбооны Олон улсын мэргэжлийн практик хүрээ, нэр томъёоны тайлбар толь зэргийг чиг үүргийн хүрээнд судалсан.	01.01 06.30	100%
2	Арга хэмжээ 2. Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинар болон бусад олон	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	50%	Дараах сургалт, олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байна. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хамрагдсан. 2.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэнүүдтэй	01.01 06.30	100%

	нийтийн ажилд оролцох			<p>уулзалт, сургалт зохион байгуулахад нэгжийн хамт олны хамт оролцсон.</p> <p>3. Нийслэлийн онцгой байдлын газраас зохион байгуулсан гамшгийн үеийн сургалт мэдээлэлд танхимаар болон биечлэн оролцсон.</p> <p>4. Нийслэлийн өмчийн нэгдсэн программын сургалтад 3 удаа хамрагдсан байна.</p> <p>5. Бүх нийтийн цэвэрлэгээ болон мод тарих араг хэмжээнд тус тус идэвхтэй оролцсон байна.</p> <p>6. Байгууллагын спорт хамтлагт орж, хамт олноороо спортын арга хэмжээнд идэвхтэй оролцдог.</p>		
--	-----------------------	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ӨХШХ-ИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)



.....
(П.Түвшинжаргал)

(Нэр, гарын үсэг)

2025. 06. 17

(Огноо)

----oOo---